

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүсийн
товч танилцуулга



Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүсийн удирдах зөвлөл

танилцуулга

Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүс нь анх 2010 оны 5-р сард ӨМӨЗО-ны Засгийн ордны зөвшөөрөлтэйгээр үүсгэн байгуулагдсан, 2014 оны 7-р сараас эхлэн бүтээн байгуулалтын ажлыг хийж, 2016 оны 6-р сард нэгдүгээр ээлжийн барилга байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн, 2017 оны 3-р сард ӨМӨЗО-ны Засгийн ордноос зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн болно. Уг бүс нь Эрээн хотын улсын голлон нээлттэй хөгжүүлэх туршилтын бүсийн байгуулалтын тэргүүлэх шинжтэй бүтээн байгуулалт, Эрээн хотын улсын хилийн бүсийг хөгжүүлэн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх бодлого мөн, түүнчлэн найрсаг харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх чухал алхам билээ.



ерөнхий байдал

Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүс нь Эрээн хотын авто замын боомтын зорчигчдыг шалган нэвтрүүлэх гарцын баруун талд байрлаж, 100000 кв.м, бүтээн байгуулалтын талбай 74000 кв.м, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 350 сая юань. Уг бүсэд үзэсгэлэн худалдаа, тээвэр ложистик, машины шалгуулах хэсэг, ажиллах байр, үйлчилгээний бүс зэрэг 5 бүсээс бүрдсэн болно.



【 бодлогын үндэслэл】 ӨМӨЗО-ны Засгийн ордон 2017 оны 3-р сарын 8-ны өдөр 《 ӨМӨЗО-ны Хилийн иргэдийн худалдааны бүсийн удирдлагын тухай журам(туршин хэрэгжүүлэх)》 -г баталсан. шинээр хэрэгжүүлэх журамд Шилийнгол аймгийн иргэн өдөрт 8000 юаны үнийн дүн бүхий Монгол, ОХУ-ын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад импортын гаалийн албан татвараас чөлөөлнө гэж заасан болно.



【бодлогын үндэслэл】 Эрээн хотын хилийн иргэдийн худалдааны бүс нь" засгийн ордон голлон оролцож, холбогдох байгууллага хяналт шалгалт хийж, бүс дотор арилжаа хийж,зах зээлийн журмаар үйл ажиллагаа явуулах" хэлбэрээр ажиллаж байна. бүсэд ажиллаж байгаа хяналт шалгалтын байгууллагууд нь бүс шатанд хяналт тавьж, зорчигч болон бараа бүтээгдэхүүний нэвтрэх гарц, агуулах зэргэд хуулийн дагуу шалгалт хийх болно.



зориулалтын бүсийн танилцуулга

1. импортын барааны үзэсгэлэн худалдааны А хэсэг
барилга байгууламжийн талбай 10600 кв.м, 300 лангуйн багтаамжтай.



зориулалтын бүсийн танилцуулга

【хөнгөлөлтийн бодлого】 хилийн иргэд" хилийн иргэдийн худалдааны бүсэд зорчих үнэмлэх" авч өдөрт 8000 юаны үнийн дүн бүхий бараа худалдан авахад импортын гаалийн албан татвараас чөлөөлөгднө.

【 барааны нэр төрөл】 арилжааны бүсэд Монгол, ОХУ-ын хүнсний бүтээгдэхүүн, үндэстний хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, ноос ноолууран бүтээгдэхүүн байгаа, өнөөдрийн байдлаар 60 бизнес эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна.



зориулалтын бүсийн танилцуулга

2. урьд хойд хяналт шалгалтын хэсэг: бүсийн урьд хаалга нь уг бүсийн өмнө талд байрлаж, талбай нь 420 кв.м, хойд хаалга нь уг бүсийн хойд талд байрлаж, талбай нь 1415 кв.м, тус тус хилийн шалган нэвтрүүлэх алба, гааль, хорио цээр зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.



зориулалтын бүсийн танилцуулга

3. агуулахын хэсэг: уг бүсийн баруун талд байрлаж, талбай нь 8002 кв.м, агуулах, бараа хадгалалт, тээвэр ложистикийн үйлчилгээ үзүүлнэ, гааль, хорио цээр хяналт шалгалт хийх болно.



зориулалтын бүсийн танилцуулга

4. машины шалгуулах хэсэг: уг бүсийн урьд хойд талд байрлаж, талбай нь 16000 кв.м. 300-500 машины зогсоолтой, бүсэд нэвтэрч буй авто машинд машины зогсоолын үйлчилгээ болон ачиж буулгах талбайтай.



хяналт шалгалтын байгууллагын бодлогын дэмжэлг

1." хяналты шалгалтын дүнг харилцан хүлээн зөвшөөрөх, харилцан мэдээлэл солилцох, харилцан хууль зүйн туслалцаа үзүүлэх" зарчмын дагуу, уг бүсэд нэг удаагийн гаалийн бүрдүүлэлт хийж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлсэн болно.



хяналт шалгалтын байгууллагын бодлогын дэмжэлг

2. хилийн иргэдийн худалдааны бодлогод нийцэх хийлээр нэвтэрч буй бараа, ачигч машинуудад урьдчилсан байдлаар мэдүүлэх, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. бодлогод үл нийцэх тохиолдолд буцаах арга хэмжээ авах болно. хэмжээ хэтрүүлсэн импорт экспортын бараануудыг энгийн худалдааг болон хилийн жижиг худалдаагаар тооцож хяналт шалгалт хийх болно.



хяналт шалгалтын байгууллагын бодлогын дэмжэлг


3. хяналт шалгалтын байгууллагаас бүсэд орох тээврийн хэрэгсэлд бүртгэл хийж, хилийн иргэдийн үнэмлэх болон түүний мэдүүлсэн бараа бүтээгдэхүүнүүдэд нэг удаагийн шалгалт хийнэ.



ХӨНГӨЛӨЛТИЙН БОДЛОГО

1. Монгол улсын бизнес эрхлэгчид бүсэд үйл ажиллагаа явуулах тохиолдолд, боомтын барилга орон сууцны үйлчилгээний хураамж 8 юань/ тонн-с чөлөөлнө; машины үйлчилгээний хураамж 20 юань/ ш, машины түр хугацаа ашиглах лицензын хураамж 30 юань/ ш, машины халдваргүйжүүлэлтийн хураамж 27 юань/ ш(жижиг) болон 54 юань(том)-с тус тус чөлөөлнө.

2. бүсэд орж үйл ажиллагаа явуулах дотоод гадаадын бизнес эрхлэгчдээс лангуйн түрээсний мөнгөнөөс чөлөөлж, зөвхөн худалдаан хэмжээний 5%-н хураамж авч лангуйн менежментийн зардалд тооцно.



ХӨНГӨЛӨЛТИЙН БОДЛОГО

3. бүсэд орсон машинаас зөвхөн талбайн хураамж авна: том оврын ачааны машин 350 юань/ш, дунд оврын ачааны машин 250 юань/ш, жижиг оврын ачааны машин 150 юань/ш; хэмжилтийн пүүний хураамж 1 юань/ тонн; агуулахын хураамж 4 юань/ тонн/ хоногт.

4. Иргэд, бизнес эрхлэгчдийг хилийн худалдаа хийхэд дөхөм үзүүлэх зорилгоор бүсэд тооцооны төв гаргасан болно, мэдээллийн технологийн систем ашиглан хилийн худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлж өгөх болно.



хөрөнгө оруулалт татах

Эрээн хотын Хилийн иргэдийн худалдааны бүс нь уг бүсийг сонирхож буй дотоод гадаадын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хүрэлцэн ирж үйл ажиллагаа явуулахыг урьж байна.

утас : 0479—7527222

имэйл хаяг : 654736526@qq.com

холбоо барих хүн: Алтаа

утас : 18647954545 80880059



анхаарал тавьсанд
баярлалаа.

2017/12/4